



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/410

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах хэсгийн хорооны санал авах байрны аюулгүй байдлыг хангах, иргэд сонгогчдод ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр хамгаалалтад ажиллах Цагдаагийн алба хаагчдад шаардлагатай зардлын санхүүжилтэд 42,117,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 42,117,000 (дөчин хоёр сая нэг зуун арван долоон мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2024 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

Засаг даргын 2024 оны  
06 дугаар сарын 07-ны өдрийн  
А/410 дугаар захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Д/д	Арга хэмжээ		Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Дүн	Нийт дүн
1	Сонгуулийн хэсгийн хороонд шаардлагатай материал	Харааны шил	ширхэг	186	10,000	1,860,000	13,857,000
2		Туузтай тусгаарлах шон	ширхэг	93	129,000	11,997,000	
3	Сонгуулийн хэсгийн хороодод ажиллах Цагдаагийн алба хаагчдад шаардлагатай зардал	Хэсгийн хорооны гадна талын хяналтын Wifi ip камер	ширхэг	75	250,000	18,750,000	28,260,000
4		Цахилгааны утас	метр	1860	3,500	6,510,000	
5		Сүлжээний утас	метр	2000	1,500	3,000,000	
НИЙТ							42,117,000

-oOo-